



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 4/341

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 10.2, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1.2016-2017 оны хичээлийн жилд элссэн “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-ыг хавсралтаар баталж, 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба (Ч.Ундрам), Мэдээллийн технологийн алба (А.Баатарбилэг), бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Журам батлагдсантай холбогдуулан Захирлын 2016 оны А/14 дүгээр тушаалаар батлагдсан “2015-2016 оны хичээлийн жилд элссэн Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-ыг 2017 оны 02 дугаар сарын 02- ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ



Захирлын 2016 оны ... дугаар сарын ...
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

7400972 9104399

Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь МУИС-д элсэн суралцаж, ерөнхий суурь хичээл судалсан оюутнуудад бакалаврын зэрэг олгох мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой аливаа асуудлыг зохицуулахад оршино.
- 1.2. МУИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургууль (эдгээрийг нэгтгэн бүрэлдэхүүн сургууль гэнэ)-д элсэж, ерөнхий суурийн 24-өөс доошгүй багц цагийн хичээл судалсан оюутан цаашид суралцах мэргэжлийн хөтөлбөрөө хаврын улирлын эцэст сонгоно. CR үнэлгээтэй хичээлүүдийн багцийг судалсан багцад оруулан тооцно. СИСИ системд оюутны баталгаажуулан судалсан, F*, NA, NR үсгэн тэмдэглэгээнээс бусад үнэлгээтэй хичээлийн багц цагийг судалсан багц цагт тооцно. Бизнесийн сургуулийн оюутны судалсан багц цагт мэргэжлийн суурь хичээлийг тооцож болно.
- 1.3. Хууль зүйн сургууль нэг хөтөлбөртэй тул энэ журам үйлчлэхгүй.
- 1.4. ЭЕШ өгч МУИС-д хувийн зардлаар элсэн суралцаж буй гадаад оюутнууд мэргэжлийн хөтөлбөр сонголтыг энэхүү журмын дагуу, сургууль хоорондын гэрээ болон Засгийн газар хоорондын гэрээгээр суралцдаг оюутны хувьд холбогдох бусад баримт бичгээр зохицуулна.
- 1.5. 2015 оноос өмнө элссэн, ерөнхий суурь хөтөлбөрийн оюутан энэхүү журмын дагуу онооны жагсаалтад орж мэргэжлийн хөтөлбөр сонгоно. Бусад сургуулиас МУИС-ийн ерөнхий суурь хөтөлбөрт шилжиж ирсэн оюутнууд мэргэжлийн хөтөлбөр сонгох шаардлагыг (журмын 1.2 заалт) хангасан тохиолдолд тус журмын дагуу мэргэжлийн хөтөлбөр сонгоно.
- 1.6. ШУС, ХШУИС-ийн оюутнууд нэгдсэн жагсаалтаар тус хоёр сургуулийн нийт хөтөлбөрөөс, бусад оюутан өөрийн бүрэлдэхүүн сургууль дээр хэрэгжиж буй хөтөлбөрөөс батлагдсан хяналтын тоонд багтаан сонгоно. МУИС-ийн байгалийн ухааны гүнзгийрүүлсэн хөтөлбөр(Honors)-т 24-өөс доошгүй багц цагийн хичээл судалсан оюутан ШУС болон ХШУИС-ийн хөтөлбөрүүдээс сонгоно.
- 1.7. Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны хурлаар хэлэлцэн баталсан мэргэжлийн хөтөлбөр бүрээр суралцах оюутны хяналтын тооны саналыг МУИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 1.8. Оюутны цаашид үргэлжлүүлэн суралцах мэргэжлийн хөтөлбөрийн жагсаалт, батлагдсан хяналтын тоог 4 дүгээр сард багтаан МУИС-ийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.
- 1.9. Мэргэжлийн хөтөлбөр сонголтыг 6 дугаар сарын 3 дахь долоо хоногийн Даваа гарагаас эхлэн ажлын 5 хоногт багтаан энэ журмын 3-р бүлэгт заасны дагуу явуулна.
- 1.10. Мэргэжлийн хөтөлбөр сонголтын баталгаажуулалтын дүнг бүрэлдэхүүн сургуулийн захиргааны хурлаар хэлэлцэн цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, суралцах оюутны талаар шийдвэр гаргана.

1.11. Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба мэргэжлийн хөтөлбөр сонгосон оюутны нэр, бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, жагсаалтын оноо, мэргэжлийн хөтөлбөр сонголтын явцын талаар санал, дүгнэлт болон бусад шаардлагатай мэдээллийг хөтөлбөр тус бүрээр гаргасныг Сургалтын нэгдсэн албанд нэгтгэж, МУИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна. Хөтөлбөр сонголтыг баталгаажуулах тушаалыг, оюутны хичээл сонголтоос өмнө зөвхөн нэг удаа гаргана.

1.12. Мэргэжлийн хөтөлбөр сонголтын үед шаардлага хангаагүй оюутнууд ерөнхий суурийн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж хөтөлбөр сонгох шаардлагыг бүрэн хангасан нөхцөлд суралцсан улирлын төгсгөлд онооны нэгдсэн жагсаалтад орж хөтөлбөрийн сонголт хийнэ.

1.13. Оюутан өөрийн хүсэлтээр мэргэжлийн хөтөлбөр сонголтоо нэг удаа хойшлуулж болно. Хүсэлтийг мэргэжлийн хөтөлбөрт санал өгөх хугацаа эхлэхээс өмнө бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд бичгээр (маягт 1) гарган шийдүүлнэ. Санал өгөх хугацаа эхэлснээс хойш хүсэлтийг хүлээн авахгүй. Хөтөлбөр сонголтоо хойшлуулсан оюутан Ерөнхий суурь хичээлийн болон чөлөөт сонголтын багц цагийг цуглуулж болно.

1.14. Оюутан хөтөлбөр сонголтоо хойшлуулсан, сонголтоос хоцорсон тохиолдолд шалтгаанаас үл хамааран дараагийн улирлын төгсгөлд үлдсэн хөтөлбөрөөс сонгож болно. Намрын улирлын төгсгөлд мэргэжлийн хөтөлбөрөө сонгоогүй тохиолдолд дараагийн хаврын улирлын төгсгөлд ерөнхий суурийн бүх оюутны нэгдсэн жагсаалтад орж хөтөлбөр сонгоно.

1.15. Мэргэжлийн хөтөлбөр сонголт хойшлуулсан шийдвэрийн дагуу оюутныг онооны нэгдсэн жагсаалтаас хасах тэмдэглэлийг сургалтын албаны бүртгэл хариуцсан мэргэжилтэн сургалтын мэдээллийн СИСИ системд мэргэжлийн хөтөлбөрт санал өгөх хугацаа эхлэхээс өмнө хийнэ.

Хоёр. Мэргэжил сонгуулах комисс

2.1. МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан мэргэжлийн хөтөлбөр сонгуулах төв болон салбар комисс (цаашид төв, салбар комисс гэнэ) мэргэжлийн хөтөлбөр сонгуулах ажлыг зохион байгуулна.

2.2. Төв комисс нь МУИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал, Сургалтын нэгдсэн албаны дарга, Мэдээллийн технологийн албаны дарга болон Сургалтын нэгдсэн албаны хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нараас бүрдэнэ. Төв комиссын дарга нь МУИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн дарга нь Сургалтын нэгдсэн албаны дарга байна.

2.3. Салбар комисс нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, сургалтын албаны эрхлэгч, сургалтын албаны хөтөлбөр, бүртгэл хариуцсан мэргэжилтнээс бүрдэнэ. Салбар комиссын дарга нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн дарга нь сургалтын албаны эрхлэгч байна.

2.4. Салбар комисс мэргэжил сонгох үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох санал хүсэлтийг шийдвэрлэнэ.

2.5. Төв комисс энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн хөтөлбөр сонголтын үед гарсан энэ журмаар шийдвэрлэх боломжгүй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.6. Суралцагчийн эцэг, эхийн төлөөлөл салбар комиссын албан ёсны зөвшөөрөлтэйгөөр хөндлөнгийн ажиглагчаар оролцож болно. Хөндлөнгийн ажиглагчаар оролцох хүсэлтээ

мэргэжлийн хөтөлбөрийн сонголт эхлэхээс долоо хоногийн өмнө салбар комисст бичгээр ирүүлсэн байна.

Гурав. Мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа

3.1. Мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа нь нэгдүгээрт хөтөлбөр бүрээр суралцах оюутны хяналтын тоог тогтоох, хоёрдугаарт тогтоосон хяналтын тоонд багтаан мэргэжил сонгуулах гэсэн хоёр үе шаттай байна. Хяналтын тоог тогтоохдоо Хавсралт 1-д заасан аргачлалыг баримтална.

3.1.1. Хөтөлбөр бүрээр суралцуулах оюутны хяналтын тоог дараах дарааллаар тогтооно:

а. Оюутан нэг хичээлийн жилд мэргэжил сонгох тандалтын судалгаанд хоёроос доошгүй удаа оролцож цаашид суралцахаар төлөвлөж буй гурван (ОУХНУС-ийн хувьд хоёр) мэргэжлийн хөтөлбөрийн саналыг сургалтын мэдээллийн системээр өгнө.

б. Эхний тандалтыг оюутан МУИС-д элсэх эрхээ баталгаажуулах бүртгэлийн үед өгнө. Хоёр дахь тандалтыг 2 дугаар сард багтаан явуулна.

в. Сургалтын нэгдсэн алба мэргэжлийн хөтөлбөр сонгох тандалтын үр дүнг тандалт явагдаж дууссанаас хойш 5 өдрийн дотор нэгтгэн МУИС-ийн захиргаа болон бүрэлдэхүүн сургуулиудад мэдээлнэ.

г. Тэнхим/нэгж нь мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоо тогтоох аргачлал(Хавсралт 1)-ын дагуу, хөтөлбөр сонгох шаардлага хангасан оюутны тоонд үндэслэн тухайн мэргэжлийн хөтөлбөрөөр суралцуулах оюутны хяналтын тооны саналаа 3 дугаар сард багтаан сургалтын албаар дамжуулан бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд хүргүүлнэ.

д. Бүрэлдэхүүн сургуулийн захиргаа тэнхим/нэгжийн саналыг хянаж, бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн хяналтын тооны талаарх саналыг, хяналтын тоо тодорхойлсон аргачлалын хамт 4 дүгээр сарын 10-ны дотор МУИС-ийн Сургалтын нэгдсэн албанд хүргүүлнэ.

3.2. Мэргэжил сонгуулах үйл ажиллагааг дараах дарааллаар зохион байгуулна:

а. Бүрэлдэхүүн сургуулийн тэнхим/нэгж, сургалтын албанаас оюутанд мэргэжил сонгохтой холбоотой мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.

б. Мэдээллийн технологийн алба сургалтын мэдээллийн системээр оюутны сурлагын голч дүн, цуглуулсан багц цаг, МУИС-д элсэхэд тооцуулсан ЭЕШ-ын оноог 68:27:5 харьцаагаар тооцож, онооны жагсаалтыг дараах томъёогоор гаргана.

$$\text{Оюутны оноо} = \frac{\text{Голч дүн}}{4.0} \times 68 + \frac{\text{Цуглуулсан багц цаг}}{42} \times 27 + \frac{\text{ЭЕШ оноо}}{800} \times 5$$

Сурлагын голч дүн бодоход сургалтын журамд заасан CR-аас бусад нэмэлт үсгэн тэмдэглэгээг тооцохгүй. Оюутны судалсан хичээлүүд дотроос амжилттай дүгнэгдсэн буюу 60 онооноос дээш үнэлгээтэй хичээлүүдийн багц цагийг цуглуулсан багц цагт тооцно.

в. Мэргэжлийн хөтөлбөр сонголт нь оюутан мэргэжлийн хөтөлбөрт саналаа өгөх, өгсөн саналаа баталгаажуулах гэсэн 2 үе шаттайгаар 6 дугаар сарын 3 дахь долоо хоногийн Даваа гарагаас Баасан гарагийн хооронд явагдана.

г. Даваа гарагийн 9.00 цагт оюутны онооны жагсаалт сургалтын мэдээллийн СИСИ системд гарна. Оюутан онооны жагсаалт гарсан Даваа гарагийн 9.00 цагаас Мягмар гарагийн 17.00 цаг хүртэл цаашид суралцах мэргэжлийн хөтөлбөрүүдэд сургалтын мэдээллийн СИСИ системээр саналаа өгнө. СИСИ систем Мягмар гарагийн 17.00 цагт хаагдах бөгөөд үүнээс хойш санал өгөх боломжгүй.

д. Бүрэлдэхүүн сургуулиас хамааран мэргэжлийн хөтөлбөрт оюутны өгөх саналын тоо ялгаатай байна. ШУС, ХШУИС, БС, ОС, ЗС-ийн оюутнууд 4, ОУХНУС 1 мэргэжлийн хөтөлбөрт санал өгөх боломжтой.

е. Мягмар гарагийн 18.00 цаг гэхэд мэргэжлийн хөтөлбөр бүрээр санал өгсөн оюутнуудын онооны жагсаалт гарна.

ё. Лхагва гарагийн 9.00 цагаас 20.00 цаг хүртэл тухайн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан оюутан сургалтын мэдээллийн СИСИ системд өөрийн эрхээр орж зөвхөн нэг мэргэжлийн хөтөлбөрөөр саналаа баталгаажуулна.

ж. Оюутан суралцах мэргэжлийн хөтөлбөрөө сонгон баталгаажуулахад бусад хөтөлбөрт түүний өгсөн санал хүчингүй болно. Энэ хугацаанд жагсаалтын дагуу хяналтын тоонд нэмж багтсан оюутнууд сонголтоо баталгаажуулах боломжтой.

з. Пүрэв гарагийн 9.00 цагаас 20.00 цаг хүртэл хяналтын тоонд нэмж багтсан оюутнуудын мэргэжил сонголтын баталгаажуулалт үргэлжлэн явагдана.

и. Пүрэв гарагийн 20.00 цагт гэхэд мэргэжлийн хөтөлбөрөө СИСИ системээр сонгож чадаагүй оюутан үлдсэн тохиолдолд Баасан гарагт онооны жагсаалтын дагуу үлдсэн мэргэжлийн хөтөлбөрөөс сонгуулах үйл ажиллагааг сургалтын алба зохион байгуулна. Энэ үед оюутан сургалтын албанаас зарласан өдөр, цагт (оюутны үнэмлэхний хамт) өөрийн биеэр хүрэлцэн ирэх шаардлагатай.

й. Годорхой хүндэтгэн үзэх шалтгаанаар мэргэжлийн хөтөлбөр сонгох боломжгүй болсон тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан сонгуулах боломжтой бөгөөд энэ талаар урьдчилан бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд мэдэгдэнэ (Маягт 2).

к. МУИС-ийн Захирлын тушаалаар хөтөлбөр сонголтыг баталгаажуулсанаар оюутан цаашид суралцах хөтөлбөрийн хичээлүүдийг сургалтын мэдээллийн системээр сонгож судлах эрхтэй болно.

Мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоог тогтоох аргачлал

1. Тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо (тэнхимийн бүтэцгүй бол бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо) бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоог тогтоохдоо энэ аргачлалыг баримтална.
2. Хяналтын тоог (тухайн хөтөлбөрт суралцах оюутны тоо) тэнхим/нэгжийн багш нарын А цагийн ноогдол, анги танхим, лабораторийн багтаамж хүрэлцээ, оюутны тандалт судалгааны дүн дээр үндэслэн тогтооно.
 - 2.1. Тэнхим/нэгжийн багш нарын А цагийн ноогдолд үндэслэн санал болгож буй оюутны хяналтын тоог бүлгээр илэрхийлэн гаргах бөгөөд тухайн хөтөлбөрөөр суралцах нэг бүлгийн оюутны тоо 25-аас доошгүй байна.
 - 2.2. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай тоноглогдсон лаборатори, өрөөний ачаалалд үндэслэн тэнхимийн лабораторийн хүчин чадлыг бүлгээр илэрхийлэн тогтооно. Лекц, семинарын анги танхимын ачааллыг МУИС-ийн хэмжээнд нэгдсэн журмаар тооцно.
 - 2.3. Оюутны тандалтын нийт дүнг сүүлийн тандалтын дүнг ашиглан тогтооно. Тухайн хөтөлбөрийн нэгдүгээр саналын нийт тоон дээр хоёрдугаар саналын тооны хагасыг нэмж бүлэгт байх оюутны тоонд хуваасны бүхэл утгаар тодорхойлно.
3. Хөтөлбөрийн хяналтын тоо нь бүлгийн тооны санал (аргачлалын 2.1 ба 4-р зүйл), лабораторийн хүчин чадал (аргачлалын 2.2 ба 5-р зүйл), оюутны тандалтын дүнд (аргачлалын 2.3 ба 6-р зүйл) үндэслэн тооцоолсон дүнгүүдийн хамгийн бага утга байна.
4. Бүлгийн тооны саналыг тогтоох дараалал
 - 4.1. Тэнхим/нэгжийн хөтөлбөрийн дэд хороо багш нарын А цагийн **багтаамж (ТЦБ)**, нийт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх А цагийн **ачаалал (ТЦА)** зэргийг нягтлан оюутны хяналтын тоог хөтөлбөр бүрээр бүлгээр илэрхийлнэ.
 - 4.2. Тэнхимийн цагийн багтаамжийг тэнхимд харьяалалтай багш нарын (01 тушаалын) А цагийн ноогдлын нийлбэрээр тооцно.
 - 4.3. Тэнхимийн багш нарын А цагийн ачааллыг, хариуцаж буй ерөнхий суурийн хичээлийн тоо, хөтөлбөрийн тоо, мэргэжлийн хичээлийн тоонд үндэслэн дараах томъёогоор тооцно. Хэмжих нэгж нь багц цаг байна.


$$\text{ТЦА} = \text{МХХ} + \text{ЕС} + \text{МД}$$

Үүнд:

МХХ – Мэргэжлийн хичээлийн цагийн ачаалал

Тэнхимийн нийт ачаалал нь хариуцан хэрэгжүүлж буй бүх хөтөлбөрийн дараагийн хичээлийн жилд 3 ба 4 дүгээр түвшний оюутнуудад заах хичээлийн нийт багц цагийн хэмжээ байна.

ЕС –Ерөнхий суурийн болон бусад хөтөлбөрийн хичээлийн цагийн ачаалал
 Өмнө хэрэгжиж буй хөтөлбөрийн сонгон суралцах хичээл, бусад тэнхим/сургуульд заах хичээлийг оруулна. Энд лекц, семинар, лабораторийн бүлгээр хичээллэх цагийг нарийвчлан тооцно.



МД –Магистр, докторын сургалтаас үүсэх ачаалал

Магистр, докторын сургалтаас үүсэх ачааллыг профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа багш нар “МУИС-ийн Багшийн орон тоо, ажлын үнэлгээний журам”-ын 3-р бүлгийн 13 заалтыг үндэслэн 3-аас доошгүй багц цагийн хичээл заана


*МД=профессор, дэд профессорын зэрэглэлийн багшийн тоо *3Бц*
 томъёогоор тогтооно.

- 4.4. Хөтөлбөр сонголтоор үүсэх бүлэгт харгалзах А цагийн ачаалал (МХШ) нь дараагийн хичээлийн жилд тухайн хөтөлбөрийн 2 дугаар түвшний оюутнуудад заах хичээлийн багц цагийн хэмжээ юм.
- 4.5. **Бүлгийн тоог тодорхойлох:** Дараагийн хичээлийн жилд хөтөлбөрүүдээр сургах боломжтой бүлгийн тоог тэнхимийн цагийн багтаамж болон тэнхимийн цагийн ачааллын ялгаврыг хөтөлбөр сонголтоос үүсэх бүлэгт харгалзах А цагийн ачаалалд харьцуулж олно:

$$\text{Бүлгийн тоо} = \frac{\text{ТЦБ}-\text{ТЦА}}{\text{МХШ}}$$

- 4.6. **Хөтөлбөр бүрээр хичээллэх бүлгийн тооны саналыг тогтоох:** Тэнхим бүлгийн тоонд багтаан хөтөлбөр тус бүрээр хэдэн бүлэг хариуцах саналаа гаргана.
- 4.7. **Тэнхимийн хяналтын бүлгийн тоог тооцсон жишээ**
 ШУС-ийн А тэнхим 2 профессор, 4 дэд профессор, 5 ахлах багш, 6 багштай, 2 хөтөлбөр хариуцдаг бөгөөд шинээр 4 хөтөлбөр санал болгож байгаа гэж саная. А тэнхимийн цагийн багтаамж болон ачааллын талаарх мэдээлэл болон хэдэн бүлэг оюутанд үйлчлэх боломжтойг тооцоолсныг хүснэгтэд үзүүлэв.

Үзүүлэлт	Тооцоолсон үр дүн	Тайлбар
ТЦБ	247	$12 \times 2 + 13 \times 4 + 15 \times 5 + 16 \times 6 = 247$
МХХ	60	3 ба 4-р курст ихэвчлэн мэргэшүүлэх хичээл орно. Оюутан нэг улиралд дунджаар 15 Бц судална гэж үзээд нэг хичээлийн жилд 30 Бц учир 2×30
ЕС	21	Нийт 7 лекцийн бүлэгт хичээл ордог гэе.
МД	18	$(2+4) \times 3$
ТЦА	99	$99 = 60 + 21 + 18$
МХШ	24	Жишээ нь: Эхний улиралд 9 Бц, дараагийн улиралд 15 Бц
Бүлгийн тоо	6	$(247-99)/24=6$. Ө.х. 6 бүлэг оюутанд үйлчлэх боломжтой.

Хөтөлбөр бүрийн саналыг тэнхим 6 бүлэгт багтаан тогтооно.	1-р хөтөлбөр- 2 бүлэг 2-р хөтөлбөр- 3 бүлэг 3-р хөтөлбөр- 1 бүлэг... гэх мэт	
---	--	--

5. Анги танхим, лабораторийн хүчин чадлыг дараах аргачлалаар тооцно. ~~Лекц, семинарын анги танхимын ачааллыг МУИС-ийн хэмжээнд нэгдсэн журмаар тооцно. Лаборатори болон зөвхөн мэргэжлийн хичээлд зориулан тоноглогдсон, олон мэргэжлийн хичээл ордог эсвэл олон хөтөлбөрт үйлчилдэг өрөөний ачаалалд үндэслэн тэнхимийн лабораторийн хүчин чадлыг тогтооно.~~
 - 5.1. Нэг улиралд нэг лабораторийн хүчин чадлыг 8-10 бүлэг гэж үзнэ.
 - 5.2. Тухайн хичээлийн жилд 3, 4-р ангид орох нийт бүлгийн тоог өрөө тус бүрээр тооцоолно.
 - 5.3. Тухайн өрөөний хувьд 20-оос 5.2-т тооцоолсон бүлгийн тоог хасахад шинэ хөтөлбөрүүдэд үйлчлэх хүчин чадал гарна.
 - 5.4. Өрөөний хүчин чадалд үндэслэн хөтөлбөр бүрээр санал болгох бүлгийн тоог тогтооно.
6. Оюутны тандалтын дүнд үндэслэн бүлгийн тоог дараах маягаар тогтооно.
 - 6.1. Оюутны сүүлийн тандалтын нийт дүнг гаргахдаа тухайн хөтөлбөрийг нэгдүгээр сонголтоор сонгосон саналын тоон дээр хоёрдугаар сонголтоор сонгосон саналын тооны хагасыг нэмж бүлэгт (25-30) байх оюутны тоонд хуваасны бүхэл утгаар тодорхойлно.
 - 6.2. Оюутны тандалтын дүн 15-аас цөөн байх тохиолдолд хөтөлбөрийн хяналтын тоог 15 гэж тогтооно.

Тэнхимийн дэд хорооны бөглөх маягт №1 (албан хэрэгцээнд)

Хөтөлбөрийн хяналтын тооны санал

(Тэнхим хэрэгжүүлэх хөтөлбөр бүрээр бөглөнө.)

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Тэнхимийн нэр	
2	Хариуцах хөтөлбөрийн нэр	
3	Тэнхимийн цагийн багтаамж (ТЦБ)	4.2 заалт
4	Цагийн ачаалал ТЦА (МХХ+ЕС+МД)	4.3 заалт
	<i>МХХ</i>	
	<i>ЕС</i>	
	<i>МД</i>	
5	МХШ	4.4 заалт
6	Тэнхимээс санал болгох бүлгийн тоо	4.5 заалт
7	Лабораторийн хүчин чадал (бүлгээр)	5 заалт
	<i>Өрөө 1</i>	
	<i>Өрөө 2</i>	
8	Оюутны тандалт (оюутны тоо)	6.1 заалт
	Нэгдүгээр саналын тоо	
	Хоёрдугаар саналын тоо	
9	Нэг бүлэгт байх оюутны тоо (25-аас доошгүй)	2.1 заалт
1	Оюутны тандалт (бүлгээр)	6.1 заалт
1	Хяналтын бүлгийн тооны санал	3 заалт

Тэнхимийн эрхлэгч


/

Огноо:

Хүлээн авсан

/

Тэнхимийн дэд хорооны бөглөх маягт №2 (албан хэрэгцээнд)



Тэнхимийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн
хяналтын тооны саналын нэгтгэл

№	Үзүүлэлт	
1	Тэнхимийн нэр	
2	Хариуцах хөтөлбөрийн тоо	
3	Тэнхимийн цагийн багтаамж (Бц-аар)	
4	Тэнхимийн цагийн ачаалал ТЦА (МХХ+ЕС+МД)	
	МХХ	
	ЕС	
	МД	
5	МХШ (нийт)	
6	Бүлгийн тоо	
7	Бүлгийн тооны санал	
	Хөтөлбөр 1	
	Хөтөлбөр 2	
8	Хяналтын тооны санал (Оюутны тоогоор)	
	Хөтөлбөр 1	
	Хөтөлбөр 2	

Тэнхимийн эрхлэгч /


Огноо:

Хүлээн авсан /



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
.....СУРГУУЛЬ
СУРГАЛТЫН АЛБА

210646 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 47. Факс: / Утас: 7730-7730-



Маягт I

МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР СОНГОЛТ
ХОЙШЛУУЛАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

1	Оюутны овог, нэр	
2	Оюутны дугаар	
3	Регистрийн дугаар	Хүйс
4	Мэргэжил сонголтоо хойшлуулах болсон шалтгаан	
5	Хүсэлт	Миний бие сарын -р сард МУИС-ийн-ны сургуульд элссэн бөгөөд энэ удаад өөрийн хүсэлтээр мэргэжил сонголтоо хойшлуулахыг хүсэж байна. Энэ хүсэлтийг гаргаснаар би мэргэжил сонголтоо дараагийн жилийн элсэгчидтэй хамт хийнэ гэдгээ ойлгосон болно.
6	Хүсэлт гаргасан оюутны гарын үсэг	
7	Хүсэлт гаргасан огноо	
8	Хүлээж авсан сургалтын албаны мэргэжилтэн	
9	Хүлээж авсан огноо	

Оюутан та, дараах АНХААРУУЛГЫГ үншиж, танилцана уу.

Оюутан та, мэргэжил сонголтоо хойшлуулах хүсэлт гаргасан тохиолдолд дараагийн хичээлийн жилийн элсэгчидтэй хамт оноогоор жагссан, мэргэжил сонголтод орох болно. Энэ үед таны төгсөх хугацаа хойшилно гэдгийг анхаарна уу.

Мөн оюутан та, тухайн мэргэжлээ сонгож чадаагүй бол, тухайн мэргэжлийг хавсарга мэргэжил байдлаар эзэмших боломжтой юм.



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
.....СУРГУУЛЬ
СУРГАЛТЫН АЛБА

210646 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 47. Факс: / Утас: 7730-7730



МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР СОНГОЛТЫГ
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧӨӨР СОНГУУЛАХ
ХҮСЭЛТИЙН МАЯГТ

1	Оюутны овог, нэр	
2	Оюутны дугаар	
3	Регистрийн дугаар	Хүйс
4	Оюутны утасны дугаар	
5	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр	
6	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар	
7	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн утасны дугаар	
	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр мэргэжлийн хөтөлбөрөө сонгуулах болсон шалтгаан	
8	Хүсэлт	Итгэмжлэгдсэн төлөөлөгч миний бие МУИС-ийн..... сургуулийн оюутан-НЫ мэргэжлийн хөтөлбөр сонголтыг заасан хугацаанд зөв сонгоно гэдгээ ойлгосон болно.
9	Оюутны гарын үсэг	
10	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг	
11	Хүлээж авсан сургалтын албаны мэргэжилтэн	
12	Огноо	

Оюутны итгэмжлэгдсэн төлөөлөгч та дараах АНХААРУУЛГЫГ үншиж, танилцана уу.
Оюутны итгэмжлэгдсэн төлөөлөгч та, мэргэжил сонголтын хугацаанд оюутныг төлөөлж сонголт хийхдээ буруу сонголт хийсэн тохиолдолд сонголтыг буцаах боломжгүйг анхаарна уу.

Жич: Иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргасан байна.